# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ДОРЖСҮРЭНГИЙН БАТДУЛАМЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗОРИЛТ 1. “САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.<br>“Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтыг зохицуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна. | Журмын төсөл боловсруулсан байна. | ЭМС-ын 2023 оны А/79 дүгээр тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | “Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтыг зохицуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/309 дүгээр тушаалаар батлуулсан. | 2024.01.02<br>2024.07.03 | 100 |
| ЗОРИЛТ 2.” ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1.<br>Улсын хэмжээнд 323 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна. | Объектын хамралтын хувь | 91% | 100% | 2024 онд 323 эмнэлэгт төлөвлөгөөт шалгалт хийхээр зарласнаас 313 эмнэлэг хамрагдаж, **97 хувьтай** байна. Дундговь аймагт байцаагч ажлаасаа гарсан шалтгаанаар 9 эмнэлэг, Хөвсгөл аймаг цаг агаарын бэрхшээлийн улмаас 1 эмнэлэг хамруулаагүй.<br>Эмнэлгүүдийн **12 хувь (37) нь их**, **49 хувь (147) нь дунд**, 39 хувь (116) нь бага эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт **73 хувьтай** байна. | 2024.01.02<br>2024.10.25 | 89 |
| | | Эрсдэлийн түвшин | Их-30%<br>Дунд-57% | Их-26%<br>Дунд- 60% | | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 66.9% | 70% | | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.1<br>Төлөвлөгөөт шалгалтын хамтарсан удирдамжийг боловсруулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалтыг улсын хэмжээнд эхлүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | | 10% | 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10-00/11 дугаартай төлөвлөгөөт шалгалтын хамтарсан удирдамжийг батлуулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалтыг улсын хэмжээнд эхлүүлсэн. | 2024.01.02<br>2024.02.28 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дэд арга хэмжээ 2.1.2. Архангай аймгийн 4 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хяналт шалгалт хийнэ. | Объектын хамралтын хувь | | 100% | Архангай аймгийн 4 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хийх хяналт шалгалтын удирдамжийн төслийг боловсруулж, нэгжийн даргаар хянуулсан боловч Эрүүл мэндийн сайдын шийдвэрээр хугацааг 3 улиралд хийхээр хойшлуулсан.<br>3 дугаар улиралд хийх удирдамжны хугацаа гадаад томилолттой давхацсан тул удирдамжид өөрчлөлт оруулж, орлон ажиллах хуваарьтай байцаагч гүйцэтгэсэн. | 2024.03.01<br>2024.09.30 | |
| | Дэд арга хэмжээ 2.1.3. Улаанбаатар хотод зарлагдсан 9 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хяналт шалгалт хийнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 20% | Улаанбаатар хотод зарлагдсан 9 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хяналт шалгалт хийхээс **100 хувь** хийж гүйцэтгэсэн. Эдгээрээс 7 эмнэлэг дунд, 2 эмнэлэг бага эрсдэлтэй үнэлэгдэж, 215 заалт бүхий 9 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгсөн. Албан шаардлагын хэрэгжилтийг тооцоход дунджаар 65 хувьтай байна. | 2024.01.02<br>2024.09.30 | |
| | | Хамралтын хувь | - | 100% | | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.4.<br>Улсын хэмжээнд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг нэгтгэж, удирдлагад танилцуулна. | | | | Шалгалтын дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эрүүл мэндийн байгууллагын зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгуулах Ажлын хэсэг байгуулж ажиллах шийдвэр гаргуулж, ЭТБГ-т хүргүүлсэн. | 2024.11.21 | |
| 3. | Арга хэмжээ 2.2.<br>Эмнэлзүйн лабораторид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Хамралтын хувь | - | 100% | 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10-00/12 урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалтыг улсын хэмжээнд **100 хувь хамруулан** хийсэн.<br>38 лабораторит 212 заалт | 2024.02.15<br>2024.06.10 | 100 |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 60% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг бүх лабораторид хийсэн ба 36% (10)-д ажлын байранд, 64% (28)-д нь ирүүлсэн баримт бичгийн хүрээнд хийхэд нийт 212 заалтын 40% (84)-ийг бүрэн хэрэгжүүлсэн ба 11% (23)-ийг маш хангалтгүй хэрэгжүүлж, дунджаар **81.9%-ийн** хэрэгжилттэй байна.<br>Шалгалтын дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эрүүл мэндийн байгууллагын зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгуулах Ажлын хэсэг байгуулж ажиллах шийдвэр гаргуулж, ЭТБГ-т хүргүүлсэн. | | |
| **4.** | Арга хэмжээ 2.3.<br>Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийж буй эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт зохион байгуулна. | Объектын хамралтын хувь | | 100% | 1. Хяналт шалгалт хийгдсэн. 12 нэгдсэн эмнэлэг, 7 дүүргийн Эрүүл мэндийн төв, 12 хувийн хэвшлийн эмнэлэг, 1 БОЭТ нийт 32 эмнэлгийн ходоод, улаан хоолойн дурангийн үзлэг, оношилгооны хэсэг тус хамрагдаж, **хамралт 100 хувьтай** байна.<br>Хяналтаар дэмжих төвтэй 11 эмнэлгийн 54 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, 33 хувь нь амбулаторийн үзлэг, эрт илрүүлгийн дуран хамт ашиглаж байгаа ба мөн 33 хувь нь зориулалтын халдваргүйжүүлэх ариутгах автомат машингүй, 25 хувьд нь ариутгалын ажилтан мэргэшээгүй байна. Үзлэг бүрийн дараа ходоод, улаан хоолойн дуранг угааж, халдваргүйжүүлж байгаа эсэхийг шалгахад 4 эмнэлэг (Багануур, Сүхбаатар | 2024.01.26<br>2024.11.01 | 100 |

158

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүүргийн ЭМТ, Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Мандал Нэгдсэн эмнэлэг) цаг хүрэлцэхгүй байдал тогтоогдсон. Удирдлагын шийдвэрээр НЭМГ-т 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 9/3763 дугаартай албан бичиг хүргүүлж, 18 эмнэлэгт дэмжлэгт хяналт шалгалтыг хийсэн.<br>Хяналт шалгалтын явцад илэрсэн дутагдлыг арилгуулахаар 7 эмнэлэгт 17 заалт бүхий улсын (ахлах) байцаагчдын хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 1 ААН (Хэлт рөүд ХХК)-д Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 3000.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч бүрэн барагдуулж ажилласан.<br>2.ТНбД-ын баталсан удирдамжийн дагуу 5 аймгийн Эрүүл мэндийг дэмжих төв, 5 сумын Эрүүл мэндийн төв, 1 аймгийн хувийн хэвшлийн эмнэлэгт СХГ-аас ЭТҮГ, НЭМГ-тай хамтран ажиллаж, дурангийн багажийг угаах зориулалтын тосгуургүй, ариутгалын ажилтнууд мэргэжил олгох сургалтад хамрагдаагүй, нян судлалын аргаар дурангийн ариутгалын чанарыг шалгах асуудал бүрэн хэвшээгүй зэрэг асуудлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Эрүүл мэндийн дэд сайдын баталсан “Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх төлөвлөгөө-нд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орсон ажил тул биелэлтийг гаргаж, НЭМГ-т хүргүүлсэн. | | |
| 5. | Арга хэмжээ 2.4.<br>Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | - | 100% | Баянхонгор аймгийн НЭ-ийн Үйлдвэрчний хорооноос ирсэн өргөдөл, удирдлагын шийдвэрээр 2024 оны 01 дүгээр сард төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн.<br>Шалгалтад аймгийн НЭ, ЭМГ хамрагдсан ба удирдах албан тушаалтан, эмч мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн дутагдлыг арилгуулахаар Нэгдсэн эмнэлэгт 28 заалттай албан шаардлагаар үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцоход **78.9 хувьтай байна.** | 2024.01.30<br>2024.03.26 | 100 |
| | | Зөрчил арилгалтын хувь | 78.5% | 79 | | | |
| 6. | Арга хэмжээ 2.5.<br>Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | | 100% | Улсын хэмжээнд ААНБ-аас ирүүлсэн 75, СХГ (өөрт) 4 хүсэлтийг **100 хувь** шийдвэрлэж ажилласан. Үүнд:<br>1.**<u>Зураг төсөл</u>**<br>Эрүүл мэндийн барилга байгууламжийн зураг төсөл хянуулах 57 /10 аймагт 34) Улаанбаатар хотод 23/ хүсэлтийн 51 /89%/-т нь эрүүл ахуйн шаардлага хангасан, 6 /11%/-д нь шаардлага хангаагүй дүгнэлт гаргасан. ЭА-н шаардлага хангаагүй зөрчил нь эмчилгээ, оношилгооны өрөө дутагдалтай, рентгений хананд тугалган хамгаалалтгүй, ариун цэврийн өрөө болон ХБИ зориулсан бие засах газаргүй, ажлын зураг нь эх загвар зургаас болон архитектор төлөвлөлтийн даалгавраас зөрүүтэй зэрэг байлаа.<br>**<u>2.Ашиглалтад хүлээн авах</u>** | 2024.01.02<br>2024.12.02 | 100 |

180

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **комисс**<br>18 хүсэлт хүлээн авснаас СЭМТ-ийн өргөтгөл 2, СЭМТ 4, ӨЭМТ 1, 3 аймгийн НЭ-ийн өргөтгөл, хувийн хэвшлийн ортой 2 эмнэлэг, ЗӨСТ-1, НЭМТ 1, Нөхөн үржихүйн ЭМ-ийн төв 1, эмнэлгийн үйлчилгээтэй орон сууц-1, эмийн сан 1 НИЙТ 4 өргөтгөл, 12 эмнэлгийн /нийслэлд 3, 7 аймагт 15/ барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах 18 комиссын бүрэлдэхүүнд ажилласан.<br>Үүний 16 (7-г үүрэг өгч, хэрэгжилтээр, 9-г шууд) барилга буюу 89%-ийг ашиглалтад хүлээн авсан. Үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ашиглалтад авахаар хүлээгдэж байгаа 2 барилга байгаа ба үүний 1 нь зураг төслийн дагуу баригдаагүй тул ЗТХ-ийн 6.17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн 3000000 төгрөгийн шийтгэл ногдуулсан.<br>**3.СХГ-т** буюу өөрт ирсэн 4 хүсэлтийн 1 барилга нь БОЭТ-ийн мэс заслын хэсгийн засвар, шинэчлэлтийн зураг төсөл, 3 нь орчны эрүүл ахуйн хяналтад хамаарах зураг төсөл байсан ба хянаж, 4 дүгнэлт гаргасан. | | |
| 7. | Арга хэмжээ 2.6.<br>Иргэн, ААН-ийн хүсэлтээр хяналтын чиглэлд хамаарах түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу ХӨСҮТ, 5 ААН-ийн хүсэлтээр цусны ийлдэс, цусны сийвэн, шээсний сорьцыг АНУ, БНСУ, Австрали, ХБНГУ руу илгээх **нийт 77 дүгнэлт** гаргасан. Үүнд: Монголын үндэсний | 2024.01.02<br>2024.11.18 | 100 |

161

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | допингийн эсрэг байгууллагад БНСУ, ХБНГУ руу допингийн шинжилгээний зорилгоор илгээх шээсний сорьцны 40, Ливэр центр ХХК-д судалгааны зорилгоор АНУ, БНСУ руу илгээх цус, шээс, сийвэнгийн 18, Мон Адонис ХХК-д оношилгооны зорилгоор АНУ руу гаргах цусны 7, Реженератив медикал сентр ХХК-д оношилгооны зорилгоор БНСУ руу илгээх цусны 5, Си Эл Дабль Ю Эйч ХХК-д оношилгооны зорилгоор БНСУ руу илгээх цусны 5, ХӨСҮТ-д судалгааны зорилгоор Япон, Австрали улс руу илгээх цусны 2 дүгнэлт байна. | | |
| 8. | Арга хэмжээ 2.7. Хяналт шалгалтын нэгтгэл, тайланг ЗГХЭГ-т хүргүүлнэ. | Албан тоот, хяналт шалгалтын тайлан | 12 дугаар сарын 10-ны дотор хүргүүлдэг | 2024 оны Хяналт шалгалтын нэгтгэл, тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | 2024 оны Хянадлт шалгалтын төлөвлөгөөнд ьуссан 245 хяналт шалгалтын мэдээллийг нэгтгэж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны албан бичгээр болон ирүүлсэн цахим хаягаар Хяналт үнэлгээний үндсэний хороонд хугацаанд нь хүргүүлсэн. | 2024.12.05 | 100 |
| ЗОРИЛТ 3. “УЛСЫН БАЙЦААГЧДЫН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛЖ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ИЛ ТОД, ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 9. | Арга хэмжээ 3.1. Орон нутгийн улсын байцаагчидтай хяналт шалгалтыг хамтран хийж, ажлын байранд сургалт хийнэ. | Ажлын байрны сургалтын тоо | | 2-оос доошгүй | - Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2024 оны 01-05 дугаар сард Баянхонгор аймагт төлөвлөгөөт бус, Орхон, Хөвсгөл аймагт дэмжлэгт хяналт шалгалт хийж, дээрх аймгийн 3 улсын байцаагчид хяналт шалгалтын арга барил, анхаарах асуудал, шалгалтын дүн танилцуулах, авах арга хэмжээний санал боловсруулах зэрэг асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын байрны сургалт хийж ажилласан. | 2024.01.30<br>2024.12.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Улсын байцаагчдын зөвлөгөөний үеэр орон нутгийн байцаагчдад ISO нэвтрүүлсэн Интермед эмнэлгийн ХАЯТТ-ийн үйл ажиллагаатай танилцуулж, олон улсын стандартын шаардлага хангасан ажлын байрыг үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангасан. | | |
| 10. | Арга хэмжээ 3.2. Аймаг, нийслэлийн ЭМГ-ын улсын байцаагчдын зөвлөгөөн зохион байгуулна. | Зөвлөгөөний тайлан | 2023 онд цахим сургалт зохион байгуулсан | Зөвлөгөөн зохион байгуулсан байна. | 2024 оны 05 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд ЭМЯ-ны СХГ, аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч ЗХЖШ, ХХЕГ, УБТЗ болон ЭЭХХЗГ-ын нийт 130 улсын байцаагчийг хамруулан зохион байгуулсан.<br>“Хяналт шалгалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох”, “Улсын байцаагчдыг чадавхижуулах” үндсэн зорилтуудын хүрээнд илтгэлүүд тавигдахаас гадна хяналт шалгалтад ашиглах журам, зааврын шинэчилсэн төслийг хэлэлцүүлж, байцаагчдын саналыг авч ажилласан. Зөвлөгөөнөөр улсын байцаагчид онолын мэдлэгээ бататгах, шинэчлэн боловсруулсан журам, зааврын төслийг болон бусад тулгамдаж буй асуудлаа хэлэлцсэн. | 2024.04.01<br>2024.05.10 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.**<br>“Процессын дахин | Нөхцөл байдлын шинжилгээ | - | Нөхцөл байдлын шинжилгээ | ЭЭХЗГ-ын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх үүргийн дагуу 14 үйл ажиллагааны 25 процессын | 2024.03.18<br>2024.04.18 | 100 |

18

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | инженерчлэлийн талаар авах зарим арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажилд хамтран ажиллана. | . | | хийж, хүлээлгэн өгсөн байна. | зураглал хийсэн. Мөн хууль эрх зүйн орчны болон 6 нэгж, 53 албан хаагчийн чиг үүргийн шинжилгээг хийж, 23 ААН, байгууллагын 28 хүнтэй бүлгээр болон ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж, ажилласан. Агентлагийн ашиглаж буй 8 цахим программыг нэгж бүрээр системийн ашиглалт, зураглалыг мөн хийж, дээрх ажлуудын үр дүнд ЭЭХХЗГ-ын нөхцөл байдлын судалгааны тайланг бичиж, танилцуулан, төслийн үндсэн багт хүлээлгэн өгсөн. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлиййн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.<br>"Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшинг үнэлэх" судалгааны ажил хийнэ. | Судалгааны тайлан | - | Судалгаа хийсэн байна. | "Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшинг үнэлэх үнэлгээ"-ний 4 бүлэг судалгааг 319 эмнэлэг /төрийн 130, хувийн 189/-т хийж тайланг бичсэн.<br>ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн хяналтын хамтарсан хөтөлбөрийн боловсруулсан эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшинд гарч буй ахиц дэвшлийг дэлхийн, бүсийн түвшинд мэдээлдэг арга зүйг анх удаа ашигласан нь энэхүү ажлын шинэлэг тал юм. Энэхүү | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |

184

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | судалгааны үр дүн Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшний суурь үзүүлэлт болж, ДЭМБ-ын "Wash in Health care Facilities 2023 Data update" сэтгүүлд хэвлэгдсэн.<br>Мөн ЭМБ-ын УАЦЭА-н үзүүлэлтийг эрүүл мэндийн үзүүлэлтэд оруулахаар ЭМХТ-тэй хамтран маягтын хэлбэрт оруулаад байна. | | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Мэргэжлийн болон хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | | 2-оос доошгүй | -Халдварт евчний эпидемиологи мэргэжлээр зэргийн шалгалт өгч "Ахлах" зэрэг хамгаалсан.<br>-9 дүгээр сард ЭМЯ, ХӨСҮТ-ээс зохион байгуулсан "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежент, халдварын сэргийлэлт хяналтын сургагч багш бэлтгэх сургалт"-д хамрагдаж, гэрчилгээ авсан.<br>-БНХАУ-ын Чанзоу хотод "Хөгжиж буй орнуудын албан хаагчдад зориулсан боомт дахь нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо" сэдэвт 14 хоногийн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан. | 2024.05.20<br>2024.09.27 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Д.БАТДУЛАМ

2024.12.05